

БУГАТ СУМЫН ХУЖИРТ БАХ-ЫН ХАДЛАН УСЖУУЛАН, ХАШИЖ ХАМГААЛАХ “АРВИН ХАДЛАН” ЖИЖИГ ТӨСӨЛ



Бугат сумын хужирт БАХ-ын хадлан усжуулан, хашиж хамгаалах “арвин хадлан” жижиг төсөл

ХЭРЭГЖҮҮЛСЭН ХУГАЦАА: 2020 ОНЫ 5- 9 САР

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТӨГ:5,500,000

Төсөл хэрэгжсэн газар

Баян Өлгий аймаг Бугат сум
Хатуу багийн Хужирт БАХ-ын
Хар усан голын эрэг

Төслийн зорилго

Бэлчээр нутагаа сэлгээн,
өнжөөхийн тул хугацаандаа
зусланд нүүдэг, бэлчээрийн
даацыг таруулахын тул отор
нүүдэл хийдэг БАХ-ийн малчдын
өвс тэжээлийн нөөцийг
бүрдүүлэх, хөдөлмөрийг
хөнгөвчлөх, илүү зарлагыг
багасгаж, амжиргааг
сайжруулах, цаашид БАХ-ын
малчдын амжиргааны эх үүсвэр
болсон бэлчээр нутагаа
хамгаалахад дэмжлэг үзүүлэхэд
оршино.

Үйл ажиллагаа

- 1.Малчид нийлж шийдвэр гаргав.
- 2.Хадлангийн талбайн усалгааны сувгуудыг татав.
3. Талбайн асгатай чулууг түүж, овоолж хашаалахад бэлтгэсэн.
4. Хашаалах чулуун материал,

бэлтгэж татах.

5. Хашааны чулуун өрлөг хийх.
6. Өрхүүд хадлангаа хадаж өвсөө хураасан.

Төслийн хөрөнгө оруулалт

Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Санхүүжилт, төгрөг
Төслөөс	2.000.000
ОНХС	0
СБАХ	0
Малчид	3,500,000
Нийт	5,500,000

Төслийн санхүүжилт буцалтгүй



Хашаалахаас өмнөх байдлын талбайн зураг .



Хашаалсаны дараах байдлын зураг

Сургамж

Малчдын хэсэг, бүлгийн малчид үнэн сэтгэлээсээ нийлж чадвал, төслөөс дэмжлэг авч их ажил бүтээн байгуулж үр шимийг хүртэж чаддагийг харуулсан, бусад малчдад үлгэр дуурайлал болсон ажил байна

Хөрөнгө оруулалтын зарцуулалт

№	Хөрөнгө оруулалтын зарцуулалт	Хэмжих нэгж	Тоо	Нэгжийн үнэ, төг	Нийт, төг
1	Дунджаар 5 км-ээс чулуу зөөх тээврийн хөлс	рейс	144	13,500	1,944,000
2	Хөдөлмөрийн багаж /хүрз, лоом, жоотуу/	ком	5		56,000
	Нийт				2,000,000


Борлуулалт, үйлчилгээний орлого /орон нутгийн ханьш 500,000төг /

№	Бүтээгдэхүүн, үйлчилгээ	Хэмжих нэгж	Тоо	Нэгжийн үнэ	Нийт, төг
	Машин өвс	ш	5	500,000	5,000,000
	Нийт				2,500,000

ТӨСЛИЙН ҮР ДҮН

Төсөл хэрэгжихээс өмнөх үетэй харьцуулахад төсөл хэрэгжснээр гарсан үр дүнгүүдийг тодорхой тоо баримттай, график дүрстэй оруулав. Үүнд:

- ↑ 2019 онд 2 машин өвс авсан бол 2020 онд 5 машин өвс авч ашигтай ажилласныг графикаар харуулав.



- ↑ Борлуулалт нэмэгдсэн байдал

Он	Авсан өвс /Хэмжээ: Машин/	Борлуулсан үнэ	Нийт үнэ	Үр шим хүртсэн

				малчин айлын тоо
2019 он	3	400000	1200000	10
2020 он	5	500000	2500000	15

- ↑ шинээр бий болсон хөрөнгө: **Хашсан хадлангийн талбайтай болсон.**
- ↑ цэвэр ашиг, **хадлангийн зардалаа хасаад 500,000 төгрөг байна.**
- ↑ Нийгмийн ашиг тус: **Айл өрхүүд өрхийн орлого хэмнэгдэж, малчдын тэжээлийн найдвартай нөөц бий болох боломж олгосон. Бод малаа хашаалах боломжтой болсон.**

Уг төсөл хэрэгжсэнээр эхний жил 5 машин буюу 12,5 тн өвс хадаж нөөцөлсөн байна..

ТӨСЛИЙН ҮР ШИМ ХҮРТЭГЧ

Төслийн үр шимийг хүртсэн нэг болон нэлээн хэдэн хүн, байгууллагын өөрсдийнх нь ярьсан яриаг тухайн хүний харъяагдах аймаг, сум, байгууллага, БАХ-ийн нэр, овог нэртэй нь бүтэн оруулж бичив.



Бугат сум Хатуу багийн Хужирт БАХ-ын малчин М.Болысбай: Бугат сумын Хатуу багийн Хужирт БАХ нь уул, хадтай хадлангийн талбай маш хомс БАХ-уудын нэг юм. Малчин өрхүүд намар Хатуу, Харусын голын эргээс бага хэмжээний өвс тэжээл бэлтгэн авдаг, голдуу аймгийн зах дээрээс худалдан авч их зарлага гаргадаг юм. Бэлчээрийн хүрэлцээ муу тул малаа онд мэнд оруулахын тулд отор, нүүдэл их хийдэг уламжлалтай. Мал төллөх үеэр өвс тэжээл маш их шаардагдана. Иймд хэсгийн малчид санал гарган Сумын малчдын байгууллагад хүсэлт гарган, төсөл оруулсан байсан. Манай төслийг хүлээн авч хөрөнгө мөнгөөр тусалсан Аймаг, сумын бэлчээр ашиглагчдын холбоо, Ногоон алт, малын эрүүл мэндийн төслийн хамт олонд баярлаж байна.

Хатуу багийн Хужирт БАХ-ын ахлагч Каусар Орынбай: Манай багийн 15 гаруй малчид хөрөнгө хүчээ нэгтгэн 5 га хадлангийн талбайгаа 5,500,000 төгрөгөөр хашиж

хамгаалж авсандаа маш их баярлаж байна. Тус хадлангийн талбайд хашаалаагүй байхад ойрхон зусдаг зарим айлуудын адуу мал байнга орж идэж, сүйтгэдэг байлаа. Тус БАХ-ын хэсэг, бүлгийн малчид бэлчээр, хадлан хамгаалахад дагаж мөрдөх журмаа сайн биелүүлдэг зусланд эрт гарч, намар оторт байж, орой бууж бэлчээр нутгаа хамгаалах сайн талтай. Иймд Малчдыг хэсэг, бүлгийн зохион байгуулалтанд оруулж хамтарч ажилласаны ачаар малчин өрхөд чухал хэрэгтэй ажлыг хийж чадлаа гэж бодож байна. Тус ажлыг хийж гүйцэтгэхэд шаардлагатай мөнгөн хөрөнгийг болон малчдыг нэгтгэн зохион байгуулалтанд оруулахад тусалсан аймаг, сумын малчдын байгууллага, Ногоон алт, малын эрүүл мэнд төслийнхэнд маш их баярлалаа. Сайн үйлс дэлгэрэх болтугай.